



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/191

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
өвлүүлж эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Наваанпэрэнлэйн Пүрэвдорж газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөж авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан өв залгамжлагч иргэн Пүрэвийн Мөнгөнтуулд Хэрлэн сумын 4 дүгээр баг Тариаланчид гудамж 406-01 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 399 м2 газрыг өвлүүлж эзэмшүүлсүгэй.

2. Иргэн П.Мөнгөнтуулын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн П.Мөнгөнтуулд даалгасугай.

5. Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А/191 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА